



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 01 өдөр

Дугаар 8733

Улаанбаатар хот

**Боловсролын байгууллагуудын
удирдах ажилтнуудыг арга хэмжээнд
оролцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 31.1.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн боловсролын газраас зохион байгуулж буй “Боловсролын байгууллагуудын удирдах ажилтны дунд зохион байгуулагдах спортын 5 төрөлт тэмцээн”-д дүүргийн боловсролын байгууллагуудын удирдлагуудыг бэлтгэн оролцуулахыг Боловсролын хэлтэс (Ш.Баасансүрэн)-т үүрэг болгосугай.

2. Арга хэмжээнд оролцоход шаардагдах төсвийг хавсралтаар баталж, 3.065.000 (Гурван сая жаран таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2026 оны 04 дугаар сарын 01 -ны өдрийн
173 дугаар захирамжийн хавсралт



ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХОД ШААРДАГДАХ
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг Бүрийн үнэ	Нийт үнэ
1	Тэмцээний зардал	баг	1	3,065,000	3,065,000
Нийт зардал					3,065,000